

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба эдгэрүүлэх зүй ёсны зарчим (Therapeutic justice): Мэргэжилтний процессын статусыг тодорхойлох нь*

Цэнд-Аюушийн ЭНХТУУЛ*

-
- I. Удиртгал
 - II. Гэр бүлийн маргааны өнөөгийн нөхцөл байдал: Статистик дүн шинжилгээ ба уламжлалт тогтолцооны сул тал
 - III. Уламжлалт мэтгэлцэх зарчмаас "Эдгэрүүлэх зүй ёс" (Therapeutic Justice)-руу шилжих нь
 - IV. Процессын хуулиудын дунд үүсэж болох зөрчил: "Шинжээч" хэмээх нэр томьёоноос үүдэлтэй эрх зүйн хийдэл
 - V. Гадаад орны туршлага: Австрали болон Сингапур Улсын шүүхийн жишээ ба хариуцлагын тогтолцоо
 - VI. Судалгааны хязгаарлалт болон цаашид судлах шаардлагатай асуудлууд
 - VII. Дүгнэлт, Санал
-



- * Энэхүү бүтээл нь Төв аймагт шүүх байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын гавьяат хуульч Ч.Доржгочоо, М.Могноон нарын нэрэмжит "Шилдэг илтгэл" шалгаруулах уралдааны "Судлаач" ангилалд III байр эзэлсэн болно.
- * Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант.



Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба эдгэрүүлэх зүй ёсны зарчим (Therapeutic justice): Мэргэжилтний процессын статусыг тодорхойлох нь

Цэнд-Аюушийн ЭНХТУУЛ

Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант.

Хураангуй: Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргаан нь хүүхдийн дээд эрх ашиг, гэр бүлийн сэтгэл зүйтэй салшгүй холбоотой байдаг онцлогтой тул түүнийг ердийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх зарчмаар шийдвэрлэх нь үр дагавар муутай, хүүхдэд хоёрдогч сэтгэл зүйн гэмтэл учруулах эрсдэлтэй байдаг. Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсад шинээр байгуулагдах Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүхийн үйл ажиллагаанд зориулан боловсруулсан "Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн төсөл дэх мэргэжилтний эрх зүйн байдлыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмуудтай харьцуулан, "Эдгэрүүлэх зүй ёс" (Therapeutic Jurisprudence)-ны зарчмын үзэл баримтлалд тулгуурлан судалсан болно.

Уламжлалт мэтгэлцэх зарчим нь хүүхдэд сэтгэл зүйн хоёрдогч гэмтэл учруулдаг болохыг шүүхийн эвлэрүүлэн зуучлал болон шийдвэр гүйцэтгэлийн статистик тоо баримтууд нотолж байгаа бөгөөд шүүхэд нийгэм-сэтгэл зүйн мэргэжилтний оролцоо зайлшгүй шаардлагатай байна.

Гэвч хуулийн төсөлд уг мэргэжилтнийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүх шинжилгээний тухай хуулийн хатуу зохицуулалт бүхий "Шинжээч" хэмээх нэр томъёогоор хуульчилсан нь процессын эрх зүйн суурь зарчим (мэтгэлцэх зарчим, нотлох баримтыг чөлөөтэй үнэлэх, шинжээчийн хараат бус байдал)-тай зөрчилдөж, хууль хэрэглээний хийдэл үүсгэх эрсдэлтэй байна. Иймд тус судалгаагаар шүүн таслах ажиллагааны сүүлийн 5 жилийн статистикт дүн шинжилгээ хийж, Австрали, Сингапур Улсын шүүхийн тогтолцоо дахь "Гэр бүлийн зөвлөх"-ийн институтийг харьцуулан судлах замаар хуулийн төсөл дэх нэр томъёо болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ИХШХШТХ) хооронд үүсэж болох зөрүүтэй байдлыг арилгах арга замуудыг санал болгохыг зорилоо.

Түлхүүр үг

Эдгэрүүлэх зүй ёс (Therapeutic Justice), мэтгэлцэх зарчим, гэр бүлийн зөвлөх, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч, хүүхдийн дээд эрх ашиг.



I. УДИРТГАЛ

Сэдвийн судлагдсан байдал

Гэр бүлийн маргааныг зөвхөн хууль зүйн маргаан гэхээсээ илүүтэйгээр нийгэм-сэтгэл зүйн хямрал гэж үзэх хандлага олон улсад түгээмэл болсоор байна. 1990-ээд оноос судлаач David Wexler, Bruce Winick нар "Эдгэрүүлэх зүй ёс" (Therapeutic Jurisprudence) хэмээх эрх зүйн философийг анх дэвшүүлсэн байдаг¹. Энэхүү онолын гол үзэл санаа нь хууль тогтоомж, шүүхийн үйл явц хүмүүсийн сэтгэл зүйд эмчилгээний (ээрэг, нөхөн сэргээх) эсвэл гэмтээх (сөрөг, сэдрээх) үр дагавар үзүүлдэг нийгмийн чухал хүчин зүйл хэмээн үздэгт оршино.

Иргэний хэргүүд харилцан адилгүй бөгөөд тэдгээрийг удирдах зарчим яг адил байх боломжгүй тул шүүхээс хэрэг бүрийн онцлогийг харгалзан, уян хатан удирдах хэрэгцээ шаардлага бий болсоор байгаа билээ. Тухайлбал, нийгмийн харилцааны хурдацтай өөрчлөлт, гэр бүлийн харилцааны бүтэц, хэв шинжид гарч буй өөрчлөлт нь гэр бүлийн хэрэг маргааныг илүү төвөгтэй, олон талт шинжтэй болгож байна. Үүний улмаас гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд онцгой анхаарал хандуулах, хэрэг маргааны онцлогт нийцсэн зохицуулалтыг хөгжүүлэх шаардлага улам нэмэгдсээр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Нийгмийн харилцаа, гэр бүлийн хэв шинжид гарч буй хурдацтай өөрчлөлтүүд нь гэр бүлийн маргааныг илүү төвөгтэй болгож байгаа бөгөөд шүүхээс хэрэг бүрийн онцлогийг харгалзан, уян хатан хандах шаардлага зүй ёсоор гарч байна. Улсын Их Хуралд өргөн баригдсан хуулийн төсөлд "шинжээч" гэх нэр томъёог "мэргэжилтэн" болгон өөрчлөх санаачилга гарсан хэдий ч энэ нь зөвхөн нэршлийн төдий өөрчлөлтөөр хязгаарлагдаж болохгүй юм. Шинээр бий болох мэргэжилтний үнэлгээ нь шүүхийн уламжлалт мэтгэлцэх зарчмын хүрээнд хэрхэн үнэлэгдэх, зохигчид тайлбар гаргах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх зэрэг нарийвчилсан механизм тодорхой бус хэвээр байгаа нь энэхүү сэдвийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна.

Сэдэв сонгосон үндэслэл

"Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн төсөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээдийг анхлан "Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч" хэмээн томъёолсон байсан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ болон Шүүх шинжилгээний тухай хуулийн суурь үзэл баримтлалтай зарим талаар үл нийцэх, хууль хэрэглээний тодорхойгүй байдал үүсгэх магадлалтай байна. Хууль батлагдахаас өмнө эдгээр ойлголтын зөрүүг арилгах, мэргэжилтний эрх зүйн статусыг илүү оновчтой тодорхойлох нь шүүн таслах ажиллагаа хэвийн, үр дүнтэй явагдах үндэс болох юм.

Судалгааны зорилго, арга зүй

Энэхүү судалгааны зорилго нь Эдгэрүүлэх зүй ёсны үзэл баримтлал хуулийн төсөлд хэрхэн туссаныг үнэлэх, шинээр бий болох мэргэжилтний статусыг процессын хуулийн суурь зарчмуудтай хэрхэн уялдуулах арга замыг

¹ David B. Wexler, Therapeutic Jurisprudence: The Law as a Therapeutic Agent (Carolina Academic Press, 1990), 15.



эрэлхийлэхэд оршино. Судалгаанд статистик дүн шинжилгээ, харьцуулсан эрх зүйн арга болон баримт бичгийн анализ хийх арга зүйг ашиглав.

II. ГЭР БҮЛИЙН МАРГААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ: СТАТИСТИК ДҮН ШИНЖИЛГЭЭ БА УЛАМЖЛАЛТ ТОГТОЛЦООНЫ СУЛ ТАЛ

Гэрбүлийнхэрэгхянаншийдвэрлэхшинэчилсэнтогтолцоо,мэргэжилтнүүдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд юун түрүүнд өнөөгийн шүүхийн практик, маргааны шийдвэрлэлтийн статистикт дүн шинжилгээ хийх нь зүйтэй юм. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2020–2024 оны шүүн таслах ажиллагааны тайлангаас үзэхэд гэр бүлийн маргаан тасралтгүй өсөх хандлагатай байна. Тухайлбал, гэрлэлт цуцлах маргаан 2020 онд 2,726 байсан бол жил дараалан өсөж 2024 онд 3,983 болж нэмэгдсэн байна². Хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэл мөн адил 2020 онд 1,333 байсан бол 2024 онд 1,924 хүрч огцом өсжээ³.

Мөн гэр бүлийн хэргийг шүүхээр шийдвэрлэхээс өмнө "Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа"-аар заавал дамжуулах хуулийн шаардлагатай. Гэвч Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020–2024 оны эвлэрүүлэн зуучлалын тайлангийн дүнгээс үзэхэд, гэр бүлийн маргаан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны амжилттай хэрэгжилтийн хувь дунджаар ердөө 12% орчим байна⁴. Жишээлбэл, 2024 онд 3,826 хэрэгт эвлэрүүлэн зуучлал явагдсанаас 472 нь л амжилттай болж, 3,354 хэрэг амжилтгүй болж шүүх рүү шилжжээ. Энэ нь бусад төрлийн иргэний хэрэг маргааны эвлэрүүлэн зуучлалын амжилттай хэрэгжилт (84.6%)-тэй харьцуулахад 6–7 дахин бага үзүүлэлт юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012)-ийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ" гэжээ. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн эрх зүйн маргаанд заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан байхыг шаардаж байгааг харж болохоор байна.

Гэвч энэхүү заалтыг хэрэглэхдээ практикт хүчирхийллийн 4 төрлөөс зөвхөн бие махбодын болон бэлгийн хэлбэрийг "нотлох баримттай" байх шалгуураар хязгаарлан ойлгох хандлага түгээмэл ажиглагддаг. Харин сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийг баримтаар нотлох нь хүнд, зарим тохиолдолд боломжгүй байдаг. Гэтэл НҮБ-ын Хүүхдийн сангийн (UNICEF) судалгаанд дурдсанаар гэр бүлийн хүчирхийллийн далд хэлбэрүүд болох сэтгэл санааны болон эдийн засгийн дарамт нь хүүхдийн сэтгэл зүйн хөгжилд ноцтой нөлөөлдөг⁵ байна.

Сэтгэл санааны хүчирхийлэл нь заавал хүний амь нас, эрүүл мэндэд шууд, материаллаг хохирол учруулснаар хэмжигдэхгүй. Тиймээс гэрлэгчдийн эвлэрэх

² Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2020–2024 оны "Шүүн таслах ажиллагааны тайлан"-аас нэгтгэн боловсруулав.

³ Мөн тэнд.

⁴ Мөн тэнд.

⁵ UNICEF, "A Familiar Face: Violence in the lives of children and adolescents", 2017, www.unicef.org



боломжгүй нөхцөлийг гагцхүү бие махбодын хүчирхийлэл үйлдэж, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул, хор уршиг учруулсан, эсхүл учруулж болзошгүй нь тогтоогдсон байхаар хуулиар хатуу хязгаарлах нь учир дутагдалтай бөгөөд хүчирхийлэлтэй гэр бүлд хүүхдийг байлгасаар байх нь хүний эрхийн зөрчил мөн⁶.

Мөн сүүлийн жилүүдэд гэрлэлтээ батлуулсан хүмүүс хувийн таарамжгүй байдлын улмаас тусдаа амьдрах, өөр хамтран амьдрагчтай болох зэрэг нөхцөл байдал түгээмэл болсон. Манай улсын хувьд гэрлэлтийн бүртгэлийг хосуудын харилцаа гэхээс илүүтэй бүртгэлийн шинжтэй харилцаа гэх агуулгаар нь хүлээн авах ойлголт нийтэд түгээмэл байх тул тодорхой нэг бүртгэлийн шаардлага гарах хүртэл гэрлэлт цуцлуулахаар хандахгүй тус тусын амьдралаа хөөх нь бий. Уг тохиолдолд нэгэнт өөр өөрт амьдралтай болсон хүмүүс шүүхэд гэрлэлтээ цуцлуулахаар хандахад нь эвлэрүүлэн зуучлалаар заавал дамжихыг шаардах нь ач холбогдолгүй, хугацаа алдах зэрэг нөхцөл байдлыг бий болгоно. Гэтэл практикт талууд тус тусдаа гэр бүлтэй болсон учир эвлэрэх ямар ч боломжгүй учраас шүүх дээрх хуулийн хэм хэмжээг зөрчиж, гэрлэлтийг шууд цуцалж байна⁷. Иймд гэрлэгчдийн бодит байдлыг хуульч бус өнцгөөс (сэтгэл зүй, нийгмийн үнэлгээгээр) дүгнэж чадах шүүхийн мэргэжилтний хэрэгцээ асар өндөр байгааг дээрх статистик батлан харуулж байна.

III. УЛАМЖЛАЛТ МЭТГЭЛЦЭХ ЗАРЧМААС “ЭДГЭРҮҮЛЭХ ЗҮЙ ЁС” (THERAPEUTIC JUSTICE) РУУ ШИЛЖИХ НЬ

Иргэний эрх зүйн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх уламжлалт тогтолцоо нь “Мэтгэлцэх зарчим” дээр суурилдаг бөгөөд ИХШХШтХ-ийн 6 дугаар зүйлд уг зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэс болгон хуульчилсан байдаг. Энэхүү хандлага нь эд хөрөнгийн маргаанд оновчтой боловч гэр бүлийн маргаанд хэрэглэхэд ноцтой сөрөг үр дагавруудыг дагуулдаг. Шүүх нь зөвхөн талуудын эрх, үүргийг тогтоох бус, нийгмийн болон хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах тусгай үүрэг хүлээдэг онцлогтой.

Мэтгэлцэх зарчмаар явагдсан шүүх хуралдааны явцад талууд хүүхдийнхээ асрамжийг авахын тулд нэг нэгнийхээ ёс суртахууны доголдол, алдаа дутагдлыг илчлэх, буруутгах зэргээр дайсагнах хандлагыг туйлд нь хүргэдэг. Үүний хор уршгаар эцэг эхчүүдийн хамтран ажиллах (co-parenting) боломж буурч, хүүхэд сэтгэл зүйн “хоёрдогч гэмтэл” (secondary trauma)-д өртдөг байна. Шүүх хуралдаан дээр өөрийн эцэг эсвэл эхийнхээ эсрэг “нотлох баримт” болон ашиглагдах, мэдүүлэг өгөх нь хүүхдийн тархины хөгжил, цаашдын нийгэмшилд насан туршийн шарх үлдээдэг болохыг НҮБ-ын Хүүхдийн сангийн судалгаанууд нотолдог⁸.

Энэ хүрээнд шүүхийн оролцоо, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн эрх зүйн маргаан шийдвэрлэхэд бус, гэр бүлийн харилцааг нөхөн сэргээхэд

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, Тайлангийн эмхэтгэл IX боть, 2021, 268 дахь тал.

⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, өмнөх эшлэл 6, 274 дэх тал.

⁸ UNICEF, “A Familiar Face: Violence in the lives of children and adolescents”, 2017, www.unicef.org.



чиглэх ёстой бөгөөд үүнийг эрх зүйн шинжлэх ухаанд "Эдгэрүүлэх зүй ёс" (Therapeutic Jurisprudence) хэмээн нэрлэдэг. Уг онолын гол цөм нь "Шүүхийн процесс өөрөө хүний сэтгэл зүйд гэмтээх бус, анагаах нөлөө үзүүлэх ёстой" гэсэн философи юм. Үүний тулд шүүн таслах ажиллагаанд зөвхөн хуульчдаар хязгаарлахгүй, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг "Мэргэжлийн баг" (m.ultidisciplinary approach) оролцох нөхцөлийг бүрдүүлэх явдал чухал байдаг⁹.

Монгол Улсад шинээр боловсруулагдсан "Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн төсөлд Эдгэрүүлэх зүй ёсны зарчмыг нэвтрүүлж, шүүхэд сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудыг тусгайлан ажиллуулахаар болсон нь ихээхэн давуу талтай. Гэвч шинээр нэвтрүүлж буй эдгээр оролцогчдын эрх зүйн байдлыг процессын хууль тогтоомжтой хэрхэн уялдуулах, чиг үүргийг нь ямар журмаар хэрэгжүүлэх асуудал нь хууль зүйн техникийн хувьд ноцтой хийдэл, зөрчил үүсгэж болзошгүй байгааг дараах хэсэгт дүн шинжилгээ хийв.

IV. ПРОЦЕССЫН ХУУЛИУДЫН ДУНД ҮҮСЭЖ БОЛОХ ЗӨРЧИЛ: "ШИНЖЭЭЧ" ХЭМЭЭХ НЭР ТОМЬЁОНООС ҮҮДЭЛТЭЙ ЭРХ ЗҮЙН ХИЙДЭЛ

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд Эдгэрүүлэх зүй ёсны зарчмыг нутагшуулах зорилгоор оруулж ирж буй нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг уламжлалт ИХШХШТХ-ийн "Шинжээч"-ийн концепцоор төсөөлөх, эсвэл процессын эрхийг явцуу хуульчлах нь дараах зөрчлүүдийг үүсгэж байна. Үүнд:

а. Хараат бус байдал болон эрх зүйн статусын зөрчил:

ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт зааснаар "Шинжээч" нь хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг шаардсан асуудлыг тодруулахаар шүүгчийн захирамжаар томилогддог, процессын хувьд хараат бус, хөндлөнгийн этгээд байх суурь зарчимтай. Гэтэл хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь ... шүүхийн ажилтан байна" гэж заасан нь институцийн хараат бус байдлын зарчимтай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн дотоод зохион байгуулалтад харьяалагдаж, шүүгчийн шууд удирдлага дор ажилладаг төрийн албан хаагчийг ИХШХШТХ утгаар "бие даасан шинжээч" гэж үзэх нь нотлох баримт бүрдүүлэх хараат бус байдлын зарчимтай үл нийцэх бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй юм.

б. Мэтгэлцэх зарчим болон гомдол гаргах эрхийн хязгаарлалт:

Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.3-т "үнэлгээний тайланд талууд гомдол гаргах эрхгүй" гэж заасан нь процессын эрх зүйн тулгуур зарчмуудтай зөрчилдөж байна. Хэрэв тухайн этгээдийг хууль зүйн утгаар "Шинжээч" гэж тодорхойлж, түүний гаргасан дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болох нотлох баримтаар үнэлэх тохиолдолд уг ажиллагаа нь ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд заасан "Мэтгэлцэх зарчим"-ын хүрээнд явагдах учиртай. ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4 (зохигч мэтгэлцэх эрхтэй), 47 дугаар зүйлийн 47.4 (шинжээчийн

⁹ Bruce J. Winick, "Therapeutic Jurisprudence and the Role of Counsel in Litigation", California Western Law Review 37, 1997, 105.



дүгнэлттэй танилцах, тайлбар өгөх эрх)-ийг үнэмлэхүй хязгаарлах нь Үндсэн хуулиар хамгаалагдсан "шүүхийн өмнө эрх тэгш байх, шударгаар шүүгдэх" эрхийн баталгааг алдагдуулна. Хэрэв тухайн тайлан нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болох бол зохигч түүнийг няцаах эрхтэй байх нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны амин сүнс юм.

с. Нотлох баримтын үнэлгээний онцлог:

Шинжээчийн дүгнэлт нь эд хөрөнгийн үнэлгээ, гарын үсэг зэрэг харьцангуй хөдөлшгүй, материаллаг баримтад тулгуурладаг. Харин гэр бүлийн мэргэжилтний үнэлгээ нь хувь хүний сэтгэл зүй, харилцааны хандлага зэрэг хийсвэр, чанарын (qualitative) үзүүлэлтүүд дээр суурилдаг. Тиймээс энэхүү динамик тайланг хатуу хэмжүүрээр үнэлэх нь төвөгтэй байж болох бөгөөд үүнийг ердийн нотлох баримт гэхээсээ илүү шүүгчид хүүхдийн ирээдүйн хувь заяаг оновчтой шийдвэрлэхэд чиглүүлэх зорилготой тусгай баримт хэмээн үзэх хандлага практикт илүү тохиромжтой байж болох юм.

V. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА: АВСТРАЛИ БОЛОН СИНГАПУР УЛСЫН ШҮҮХИЙН ЖИШЭЭ БА ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

Гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэхэд "Эдгэрүүлэх зүй ёс"-ыг амжилттай нутагшуулсан орнуудын туршлагыг судлах нь манай улсад үүсэж болзошгүй хууль зүйн техникийн зөрчлүүдээс гарах арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Эдгээр улсууд нийгэм, сэтгэл зүйн мэргэжилтнийг шүүн таслах ажиллагаанд татан оролцуулахдаа уламжлалт "Шинжээч"-ийн хатуу зохицуулалтаас хэрхэн салгаж, эрх зүйн тусгай статус олгосныг дараах байдлаар харж болно.

Австрали Улсын туршлага ба хариуцлагын тогтолцоо:

Гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь уламжлалт хүлээснээс татгалзаж чадсан сонгодог жишээ бол Австрали Улсын шүүхийн практик юм. Тус улс 2006 онд Гэр бүлийн тухай хуульдаа (Family Law Act 1975) өөрчлөлт оруулан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох мэргэжилтнийг "Шинжээч" (Expert witness) хэмээх хатуу статусаас чөлөөлж, шүүхийн дэргэдэх "Гэр бүлийн зөвлөх" (Family Consultant) хэмээх бие даасан, шинэ институци болгон хуульчилсан¹⁰. Австралийн Гэр бүлийн хуулийн 11A зүйлд зааснаар Гэр бүлийн зөвлөх нь шүүн таслах ажиллагаанд оролцож буй хүмүүст туслах, зөвлөгөө өгөх, маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээс гадна шүүхэд нотлох баримт гаргаж өгөх (giving evidence) чиг үүргийг хэрэгжүүлдэг¹¹. Энэхүү үзэл баримтлалын өөрчлөлт нь манай улсын хуулийн төсөлд туссан үүсэх өндөр магадлалтай байгаа "тусгай мэдлэгийн эрх хэмжээ хэтрэх" (ultra vires) эрх зүйн эрсдэлийг урьдчилан харж, оновчтой шийдвэрлэсэн сайн туршлага юм.

Австралийн шүүх эдгээр мэргэжилтнүүдийг үндсэн "Шинжээч" (Expert witness)-ийн статусаар бус, харин шүүхийн "Зөвлөх" хэмээх тусгайлсан

¹⁰ Commonwealth of Australia, Family Law Act 1975, sec. 11B.

¹¹ Ibid, sec. 11A.



статусаар хуульчилсан нь нарийн учир шалтгаантай. Уламжлалт мэтгэлцэх зарчмын хүрээнд шинжээч нь "худал дүгнэлт" гаргавал эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй байдаг нь мэргэжилтнийг айдас дарамтад оруулж, хүүхдийн сайн сайхны төлөө зоригтой дүгнэлт гаргахад нь саад болдог. Үүнээс сэргийлж Австралийн Гэр бүлийн тухай хуулийн 11D зүйлд "Гэр бүлийн зөвлөх нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гэр бүлийн шүүхийн шүүгчтэй нэгэн адил хамгаалалт, халдашгүй эрхийг (Immunity) эдэлнэ" хэмээн онцгойлон зааж, тэднийг эрүүгийн болон иргэний хариуцлагаас чөлөөлжээ¹².

Хэдийгээр гэр бүлийн зөвлөхөд дээрх хэлбэрээр тусгай хамгаалалт олгодог боловч, Австралийн эрх зүйн тогтолцоо нь талуудын процессын эрхийг үнэмлэхүй хязгаарлах хэт туйлшралаас сэргийлж чадсан байдаг. Тодруулбал, зөвлөхийн гаргасан тайлан дүгнэлт нь шүүхийн эцсийн шийдвэрийг урьдчилан тодорхойлох хөдөлшгүй үндэслэл биш бөгөөд гагцхүү ердийн "нотлох баримт"-ын хэмжээнд үнэлэгдэх хууль зүйн үр дагавартай. Иймд тайлангийн арга зүй, үр дүнд эргэлзээ төрсөн тохиолдолд зохигчид шүүх хуралдааны мэтгэлцээний шатанд холбогдох асуултыг тавих, өөрсдийн сөрөг нотлох баримтаар няцаалт хийх эрх нь хуулиар бүрэн нээлттэй үлддэг¹³. Үүгээр зогсохгүй, тус хуулийн 11C зүйлээр гэр бүлийн зөвлөхтэй хийсэн уулзалт, ярилцлагын явцад илэрсэн мэдээллийг шүүхэд нотлох баримтаар шууд ашиглаж болохоор хуульчилсан нь хаалттай хаалганы цаана, далд хэлбэрээр үйлдэгддэг хүүхдийн эсрэг хүчирхийллийг нотлон тогтоох нэн чухал хөшүүрэг болж өгдөг байна.

Сингапур Улсын туршлага:

Сингапур улс 2014 онд Гэр бүлийн шүүхээ (Family Justice Courts) шинэчлэн зохион байгуулж, Гэр бүлийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх дүрмээ (Family Justice Rules 2014) баталсан бөгөөд шүүхийнхээ албан ёсны чиглүүлэгч философийг "Therapeutic Justice" хэмээн тунхагласан¹⁴. Сингапурын "Family Justice (General) Rules 2024 дүрмийн дагуу шүүгч хэргийг дангаар, хөндлөнгийн байр сууринаас шийдвэрлэхээс илүүтэйгээр шүүн таслах ажиллагаанд "Шүүгч төвтэй хандлага" (Judge-led approach)-ыг баримталдаг¹⁵. Шүүгч нь сэтгэл зүйн зөвлөх, эвлэрүүлэн зуучлагчтай хамтарсан "Олон талт мэргэжлийн баг"-ийг удирдаж, талуудад эвлэрэх санал тавих, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах эрхтэй байдаг¹⁶.

Сингапурын зохицуулалтын бас нэгэн онцлог нь хүүхдийн нөхцөл байдлыг судлах этгээдийг үндсэн "Шинжээч" гэхээс илүүтэйгээр "Хүүхдийн төлөөлөгч" (Child Representative) болон "Хүүхдийн мэргэжилтэн" (Child Specialist) хэмээн тусгайлан хуульчилсан явдал юм¹⁷. Хүүхдийн мэргэжилтэн нь хүүхдийн сайн сайхныг (welfare of the child) нэн тэргүүнд тавьж, шүүхэд хараат бус тайлан (child report) гаргах үүрэгтэй¹⁸. Хамгийн чухал нь Сингапурын шүүхийн дүрмийн

¹² Ibid, sec. 11D.

¹³ Ibid, sec. 11C.

¹⁴ Family Justice Courts Singapore, "Report of the Committee for Family Justice: Recommendations for a Family Justice System", 2014, 10, www.judiciary.gov.sg.

¹⁵ Republic of Singapore, Family Justice (General) Rules 2024, pt. 8, rule 1.

¹⁶ Ibid, pt. 8, rule 2(2)(a).

¹⁷ Ibid, pt. 12, rule 1.

¹⁸ Ibid, rule 4(2)-(3).



12 дугаар бүлгийн 7 дугаар зүйлд “Хүүхдийн тайлан гаргасан мэргэжилтнийг гэрчээр дуудах, эсхүл түүний тайлангийн агуулга, арга зүйтэй холбогдуулан аливаа хэлбэрийн мэдүүлэг авахыг хориглоно” гэж хатуу заасан байдаг¹⁹. Ингэснээр мэргэжилтнийг нэг талаас нь хамгаалж, цэвэр хүүхдийн эрх ашигт төвлөрөх боломжийг олгосон байна.

VI. СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАЛТ БОЛОН ЦААШИД СУДЛАХ ШААРДЛАГАТАЙ АСУУДЛУУД

Энэхүү судалгааны ажил нь хуулийн төсөл дэх мэргэжилтний статусыг процессын эрх зүй (ИХШХША)-н уламжлалт зарчим, “Эдгэрүүлэх зүй ёс”-ны философийн хүрээнд хязгаарлан судалсан болно. Сэдвийн цар хүрээ, хугацаанаас хамааран тус дагнасан шүүхийн шинэчлэлтэй холбоотой дараах асуудлуудыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай хэмээн үзэж байна. Үүнд:

1. Мэргэжилтний хариуцлага, ёс зүйн тогтолцоо: Тус судалгаанд шүүхийн мэргэжилтнийг хатуу хариуцлагаас чөлөөлөх (immunity олгох) хууль зүйн үндэслэлийг дэвшүүлсэн боловч, ашиг сонирхлын зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх сахилга, ёс зүйн хариуцлагын механизмыг захиргааны эрх зүйн хүрээнд гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.
2. Институцийн чадавх болон эдийн засгийн үр нөлөө: Шүүх бүрд тусгай мэргэжилтний орон тоог бий болгох нь Шүүхийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуультай хэрхэн уялдах, шүүхийн төсөв санхүүд ямар ачаалал өгөх зэрэг прагматик асуудлууд энэхүү судалгааны хүрээнд хөндөгдөөгүй.
3. Эрүүгийн хэрэгтэй уялдах онцлог: Гэр бүлийн шүүхийн мэргэжилтэн үнэлгээ хийх явцдаа хүүхдийн эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл илрүүлсэн тохиолдолд уг үнэлгээний тайлан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар шалгуураар нотлох баримт болж шилжих тухай салбар дундын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь зүйтэй.

VII. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон улсын жишиг болсон “Эдгэрүүлэх зүй ёс” (Therapeutic Jurisprudence)-ны онол, үзэл баримтлалыг “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн төсөлд хэрхэн тусгаж, процессын эрх зүйн суурь зарчмуудтай хэрхэн уялдуулах асуудлыг тусгайлан тодорхойлохыг зорилоо.

Хуулийн төсөлд сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг шүүн таслах ажиллагаанд процессын оролцогчоор татан оролцуулах тусгайлсан зохицуулалтыг тусгасан нь гэр бүлийн маргааныг зөвхөн материаллаг эрх зүйн маргаан бус, нийгэм-сэтгэл зүйн агуулгатай өвөрмөц харилцаа болохыг хууль тогтоогчийн түвшинд хүлээн зөвшөөрсний илрэл юм. Энэ нь шүүхийн тогтолцоонд “Эдгэрүүлэх зүй ёс”-ны концепцыг нэвтрүүлэх алхам бөгөөд Гэр бүлийн шүүхийг зөвхөн маргаан

¹⁹ Ibid, rule 7.



таслагч субъект бус, гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх "нөхөн сэргээх" чиг үүрэг бүхий институт болох суурь шилжилтийн агуулгыг илэрхийлж байна.

Хэдийгээр үзэл баримтлалын хувьд дээрх суурь шилжилтийг хийж байгаа нь оновчтой боловч уг үзэл баримтлалыг процессын хуульд буулгахдаа ИХШХШТХ-ийн уламжлалт "мэтгэлцэх зарчим" болон "шинжээч"-ийн эрх зүйн статусын хүрээнд механик байдлаар уялдуулахыг оролдсон нь дотоод логикийн болон хууль хэрэглээний зөрчлийг үүсгэж болзошгүй байна. Шүүх эрх мэдлийн нөхөн сэргээх болон сэтгэл зүйн нөлөөллийг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлэхийг зорихын зэрэгцээ зохигчдын тайланд гомдол гаргах эрхийг үнэмлэхүй байдлаар хязгаарласан нь "Эдгэрүүлэх зүй ёс"-ны уян хатан, хүүхэд төвтэй мөн чанартай институцийн хувьд зөрчилдөж байна.

Статистик үзүүлэлтээс үзэхэд гэр бүлийн эрх зүйн маргаан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөө хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөлд шинээр нэвтрүүлж буй мэргэжилтний үнэлгээ, дүгнэлт нь хүүхдийн эрх ашгийг хангах хамгийн чухал чиг баримжаа болох учиртай. Харьцуулсан эрх зүйн судалгаагаар Австрали, Сингапур зэрэг орнууд эдгээр мэргэжилтнүүдийг процессын ердийн нэг нотлох баримт бүрдүүлэгч субъект бус, шүүхийн дэргэдэх бие даасан, хөндлөнгийн дарамт, нөлөөллөөс хамгаалагдсан өвөрмөц эрх зүйн статус бүхий этгээд гэж хуульчилснаар "Эдгэрүүлэх зүй ёс"-ны үзэл баримтлал бодитоор хэрэгжих нөхцөл бүрдүүлснийг харуулж байна.

Иймд "Эдгэрүүлэх зүй ёс"-ны үзэл баримтлалыг хууль тогтоомжид суулгаж, бодитоор нутагшуулахын тулд дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

Санал 1. Хуулийн төсөлд заасан "Гэр бүлийн шүүхийн мэргэжилтэн"-ийг уламжлалт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн "шинжээч" эсвэл "гэрч"-ийн загвараар бус, шүүх хуралдааны явцад хүүхдийн дээд эрх ашгийг үнэлж, тайлагнах чиг үүрэг бүхий процессын бие даасан, өвөрмөц оролцогч (sui generis) гэж тодорхойлох хууль зүйн үндэслэлийг бүрдүүлэх.

Санал 2. Төсөл дэх "үнэлгээний тайланд гомдол гаргах эрхгүй" гэх хатуу хязгаарлалтыг зохигчийн шударга шүүхээр шүүгдэх эрх (due process)-тэй нийцүүлэн уян хатан болгох.

Санал 3. Мэргэжилтэн нь зохигчдын зүгээс ирж болох аливаа сүрдүүлэг, дарамт шахалт, хувийн сэдэлтэй гомдлоос ангид байж, зөвхөн хүүхдийн дээд эрх ашигт нийцсэн бодитой үнэлгээ гаргах нөхцөлийг бүрдүүлэх.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл (УИХ-д өргөн баригдсан), 2025 он.
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
3. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
4. Шүүх шинжилгээний тухай хууль, 2022 он.
5. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, 2012 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, Тайлангийн эмхэтгэл IX боть, 2021 он.
2. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүн таслах ажиллагааны тайлан (2020–2024 он), 2024 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Bruce J. Winick, "Therapeutic Jurisprudence and the Role of Counsel in Litigation", California Western Law Review 37, 1997.
2. Commonwealth of Australia, Family Law Act 1975.
3. David B. Wexler, Therapeutic Jurisprudence: The Law as a Therapeutic Agent, Carolina Academic Press, 1990.
4. Family Justice Courts Singapore, Report of the Committee for Family Justice: Recommendations for a Family Justice System, 2014.
5. Republic of Singapore, Family Justice (General) Rules 2024.
6. UNICEF, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, New York: United Nations Children's Fund, 2017.

4. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn.
2. НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)-гийн албан ёсны цахим хуудас: www.unicef.org.
3. Сингапур Улсын шүүхийн албан ёсны цахим хуудас: www.judiciary.gov.sg.



Family proceedings and the principle of therapeutic jurisprudence: Defining the procedural status of specialists

ENKHTUUL Tsend-Ayush*

Abstract: Disputes arising from family law relations are inextricably linked to the best interests of the child and the psychological well-being of the family. Consequently, resolving these disputes through the adversarial principle of standard civil procedure is often ineffective and risks inflicting secondary psychological trauma on children. This study investigates the legal status of specialists within the draft law "On the Adjudication of Family Cases," designed for the newly establishing specialized Family and Children's Court in Mongolia, by comparing it against the fundamental principles of civil procedure and grounding the analysis in the conceptual framework of "Therapeutic Jurisprudence."

Statistical data from court-annexed mediation and judgment enforcement verify that the traditional adversarial approach inflicts secondary psychological trauma on children, underscoring the critical necessity of integrating socio-psychological professionals into court proceedings.

However, the draft law defines these professionals using the term "Expert", a role subject to strict regulations under the Law on Civil Procedure and the Law on Forensic Science. This classification conflicts with foundational procedural principles (the adversarial principle, free evaluation of evidence, and expert independence), thereby creating a risk of legal ambiguity. Accordingly, by analyzing judicial statistics from the past five years and conducting a comparative study of the "Family Consultant" institution within the court systems of Australia and Singapore, this research aims to propose solutions to resolve potential discrepancies between the terminology in the draft law and the Code of Civil Procedure.

Keywords: Therapeutic jurisprudence, adversarial principle, family consultant, family situation expert, best interests of the child.

* Master's degree candidate of School of Law, National University of Mongolia.